



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 01493

Номгон

Г Мод үржүүлгийн газруудын үйл ажиллагаатай Г  
танилцаж, дүгнэлт гаргах ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор суманд үйл ажиллагаа явуулж буй Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Мод үржүүлгийн газар, “Сум дундын ойн анги” ОНӨТҮГазрын Мод үржүүлгийн газар, “Шинэ баян сайр” ХХК-ний мод тарих үйл ажиллагаатай тус тус танилцаж, улсын болон орон нутгийн төсөв, хандив дэмжлэгээр хийгдсэн ажлын үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Т.Хишигбаатар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Г.Энхбаяр Баянхонгор сумын Засаг дарга

Э.Долгорсүрэн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Д.Оюун-Эрдэнэ Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга

Ж.Дэлгэрмаа Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч

Нарийн бичгийн дарга


Б.Намуун Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

2.Дээрх байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, хийгдсэн ажлын үр дүн, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан дүгнэлт гаргах ажлыг үр дүнтэй зохион байгуулж 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймгийн Засаг даргад танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН



642311277